

ÂÂ Энэ сарын 24-28-нд Олгий суманд боксчид хвчээ сорихоор болж байна.

Энэ тухай аймгийн биеийн тамир, спорт, соёл аялал жуулчлалын газрын дарга Х.Хайнаар мэдээлэхдээ, "Олон улсын чанартай уг тэмцээнийг бид туршлага солилцох, спортын энэ торлийг улам хөгжүүлэх үүднээс аймагтаа анх удаа зохион байгуулах гэж байна. Тэмцээнд манай улсын шилдэг боксчид болон Казахстан, БНХАУ, ОХУ-аас тамирчид уригдан ирж оролцохоор боллоо. Оороор хэлбэл бид 120 гаруй зочдод үйлчлэхийн зэрэгцээ нэрт тамирчидтай нүүр учран уулзаж, хвч авъяасыг нь харж сонирхох болно гэв.ÂÂ